

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД, САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар А/500/283

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Ургамал хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- 1."Ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД Ч.УЛААН
САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР